

ДОТООД ТОВЬЁГ

№	Баримтын индекс	Баримтын он, сар, өдөр	Баримтын тэргүү	Баримтын хуудасны дугаар	Тайлбар
0	1	2	3	4	5
1	1/3	2023.01.02 2023.12.29	Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 2023 оны биелэлт	1-18	

Дүн тоо: 1 (нэг) ширхэг баримт бичиг бүртгэв.

Дотоод товъёгны хуудасны тоо: 1 /нэг/ ширхэг

Дотоод товъёг үйлдсэн:

Мэргэжилтэн

*М. Ариун-Эрдэнэ*

М.Ариун-Эрдэнэ

2024 он 03 дугаар сарын 04

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ БИЕЛЭЛТ**

2023.12.25

Баян-Өндөр сум

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээний хувь
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох						
Зорилт-1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлтэй хамтран ажиллах	Арга хэмжээ-1: Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг нас, насны ангиллаар авч, сорилын программд шивэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх;	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ хувиар тооцно.	2022 онд хүн амын 9.4% сорилд хамруулж А, В, С үнэлгээтэй иргэдийн хувь 54	2023 онд А, В, С үнэлгээтэй иргэдийн тоог 2023 онд 56 хувьд хүргэнэ.	Бие бялдрын түвшин тогтоох сорилд хүн амын 9 хувь буюу 9631 иргэдийг хамруулснаас 56% нь А, В, С үнэлгээтэй байна.	100%
	Арга хэмжээ-2: Баян-Өндөр, Жаргалант суманд орон тооны	Баян-Өндөр, Жаргалант суманд нийт 2 арга	2022 онд Баян-Өндөр суманд 1 арга	2023 онд Жаргалант суманд 1 арга	Тайлант онд Баян-Өндөр суманд 1 биеийн тамир арга зүйч ажиллуулсан бөгөөд	50%

	биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх	зүйчтэй болсон байна.	зүйч ажилласан	зүйч ажиллуулна.	Жаргалант суманд ажиллуулах асуудал шийдвэрлэгдээгүй.	
	Арга хэмжээ-3: Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах	Аймгийн хэмжээнд нийт 10 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.	2022 онд 26 спорт холбоотой гэрээ байгуулж хамтран ажилласан.	2023 онд биеийн тамир спортын 26 төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж, чадавхжуулж ажиллана.	Тайлант онд биеийн тамир, спортын 28 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улс, бүс, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээн зохион байгуулах, оролцоход улсын төсвөөс 346,1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 390 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлж ажилласан.	100%
	Арга хэмжээ 4: Орхон аймгийн хэмжээнд спортын талбай, гэр хорооллын дундах тоглоомын талбайд тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөний хийх нөхцөлийг бүрдүүлнэ.	8 иргэд тогтмол идэвхтэй дасгал хөдөлгөөний хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Амралт чөлөөт цагийн 8 талбайд дасгал хөдөлгөөн уралдаан тэмцээнийг зохион байгуулж 1060 иргэнийг хамруулсан.	Гадна талбайд биеийн тамир спортын арга хэмжээг 10 удаа зохион байгуулж 1200 иргэнийг хамруулна.	Аймгийн хэмжээнд орон сууцны болон гэр хорооллын байршилд амралт, чөлөөт цагийн 114 талбайд иргэд, хүүхэд, залуус чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлж биеийн тамир, спортоор хичээллэж байна. Тайлант онд орон нутгийн төсвийн 741,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 амралт, чөлөөт цагийн талбай шинээр байгуулсан бөгөөд амралт, чөлөөт цагийн 5 талбайд идэвхтэй дасгал хөдөлгөөнд 700 иргэн, спортын 4 удаагийн	100%

					тэмцээнд 760 иргэн, нийт 1460 иргэнийг хамруулсан	
	Арга хэмжээ 5: Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд 28 спортын холбоодын үйл ажиллагаатай холбоотой эх өгөгдөл байршсан байна.	2022 онд 26 спорт холбоодын мэдээллийн нэгдсэн сан үүсгэж ажилласан.	2023 онд 26 спорт холбоодын мэдээллийг шинэчилж ажиллана.	Тайлант онд 22 спорт холбоодын мэдээллийг шинэчилж ажилласан.	90%
	Арга хэмжээ 6: Биеийн тамирын арга зүйчдийг мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Биеийн тамирын 6 арга зүйчийг мэргэшүүлэх давтан сургалтад хамруулсан байна.	-	2023 онд 2 арга зүйчийг сургалтад хамруулна.	Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан 6 удаагийн туршлага судлах, мэргэшүүлэх, сургалт, уулзалт зөвлөгөөнд тус газрын давхардсан тоогоор 31 албан хаагч, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын арга зүйч, мэргэжилтэн нарыг тус тус хамруулсан.	100%
Зорилт-2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх	Арга хэмжээ 1: Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубийн тоог нэмэгдүүлэх	Спортын магадлан итгэмжлэлд 5 фитнес клубийг хамруулсан байна.	2022 онд 13 фитнес клубээр хичээллэгсдийн тоог 130-аар нэмэгдүүлж,	2023 онд фитнес клубт хичээллэх иргэдийн тоог 1800-д хүргэнэ.	Тайлант онд фитнес клуб 1-ээр нэмэгдэж 14 фитнес клубт хичээллэгсдийн тоог өмнөх оноос 100-аар нэмэгдүүлж, 1900 иргэн тогтмол хичээллэж байна.	100%

ёсны салшгүй хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт, тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ			1750 иргэн тогтмол хичээллэсэн.			
	Арга хэмжээ 2: Улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	Улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа 5 удаа зохион байгуулсан байна.	2022 онд 4 удаа улс, бүсийн чанартай томоохон тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулсан	2023 онд 4 удаа улс, бүсийн чанартай томоохон тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.	Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 7, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 3 тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 1-ээр нэмэгдүүлж, нийт 3635 тамирчдыг оролцуулан зохион байгуулж, улсын төсвөөс 275 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 220 сая төгрөг, томоохон аж ахуйн нэгжүүдээс 20 сая төгрөгийн хандивийг авч зохион байгуулсан.	100%
	Арга хэмжээ 3: Спортын хэрэгслийн /дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр, чарга/ түрээсийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, иргэний санал санаачилгыг дэмжиж зам талбай, орчин нөхцлийг бүрдүүлнэ.	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй ААНБ, иргэдийн тоо жил бүр нэмэгдэж, зам талбай, орчин нөхцөлөөр дэмжиж ажилласан байна.	2022 онд 3 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, 6700 иргэн түрээсийн үйлчилгээнд хамрагдсан.	Гэрээ байгуулах аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлж, түрээсийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлнэ.	Тайлант онд 6 байршилд 6 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, цахилгаан дугуй /скүүтер/, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 7200 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа.	100%

	<p>Арга хэмжээ 4: Хүн амын зорилтот бүлгүүд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулж, хамтарч ажиллах</p>	<p>Нийт ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, зохион байгуулах арга хэмжээний тоо</p>	<p>2022 онд спортын 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 850 ахмад настан хамруулсан.</p>	<p>Спортын 9 төрлөөр 13 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 900 ахмад настан хамруулна.</p>	<p>Аймгийн ахмадууд софт волейбол, шатар, хөлбөмбөг, волейбол, граунд гольф, дартс, ширээний теннис, бадминтон, хөнгөн атлетикийн төрлүүдээр Биеийн тамир спортын газрын А, Б заал, Баян-Өндөр сумын спорт заал, аймгийн ЗДТГ-ын спорт заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Спорт цогцолборын заалуудад үнэ төлбөргүй 7 хоногт 2 цагаар хичээллэдэг. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн ахмадын хорооны чийрэгжүүлэлтийн танхимд хийн дасгалаар тогтмол 472 ахмад хичээллэж байна. Тайлант онд ыг хамрууллаа. Аймгийн хэмжээнд 6 спортын зааланд 1000 гаруй ахмадыг үнэ төлбөргүйгээр хичээллүүлж байна.</p>	<p>100%</p>
			<p>Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан</p>	<p>Биеийн тамир, спортын арга хэмжээг 9 төрлөөр 12 удаа тэмцээн зохион байгуулж давхардсан</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд биеийн тамир, спортын газрын А, Б зааланд долоо хоногт 2 удаа үнэ төлбөргүйгээр хичээллэдэг бөгөөд тайлант онд пара хөнгөн атлетик, 3x3 сагсан бөмбөг, буухиа, дартс, ширээний дуут бөмбөг,</p>	

			тоогоор 509 иргэнийг хамруулна.	тоогоор 550 иргэнийг хамруулна.	волейбол, хонхот бөмбөг, суугаа волейбол, бочи зэрэг 9 төрлөөр 360 иргэн тогтмол хичээллэж байна.	
	Арга хэмжээ 5: Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж “ Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх	Аянд хамрагдсан байгууллагын тоо, хамрагдсан хүний тоо	“Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон “Илүүдэл жингүй Эртэч Монгол аян”-д давхардсан тоогоор 44856 иргэнийг хамруулсан.	“Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон “Эрүүл Монгол хүн” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлж давхардсан тоогоор 45000 иргэн хамруулна.	“Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон “Эрүүл Монгол хүн” аяны хүрээнд “Нэг анги Нэг өглөө”, Уурхайн хот-100 км, Найрамдал дружба “Эрүүл мэнд гороо” алхалт, “Нээлттэй хаалганы өдөрлөг”, өглөөний дасгал, ажлын байрны дасгал зэрэг арга хэмжээг 26 спорт заал, биеийн тамирын чийрэгжүүлэх танхим болон амралт чөлөөт цагийн талбайд зохион байгуулж, давхардсан тоогоор 18231 иргэнийг хамруулж, орон нутгийн төсвөөс 4,8 сая төгрөгийг зарцуулсан.	90%
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг улс, бүс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүргэх						
Зорилт 3. Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа	Арга хэмжээ 1: Аймгийн хэмжээнд Иргэдийн спортын наадмыг жил бүр зохион байгуулах	Иргэдийн наадам Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн дунд	Иргэдийн спортын наадмыг Баян-Өндөр, Жаргалант	Баян-Өндөр, Жаргалант сумын 26 багийн иргэдийн	Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГ-тай хамтран "Иргэдийн спортын наадам"-ыг үндэсний болон багийн спортын 8 төрлөөр зохион	100%

хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах		спортын 8 төрлөөр зохион байгуулж 2400 иргэн хамрагдсан байна.	сумын 24 багийн иргэдийн дунд багийн болон үндэсний спортын 6 төрлөөр зохион байгуулж 767 иргэн хамруулсан.	дунд багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж, 800 иргэн хамруулна.	байгуулж, 1161 иргэнийг хамруулсан.Үүнд: сагсан бөмбөгийн төрөлд 308, волейболын төрөлд 384, орс таталтын төрөлд 184, ширээний теннисний төрөлд 46, үндэсний бөхийн төрөлд 69, буудлагын төрөлд 92, дартсын төрөлд 46, Мас- рестлинг /Модон барилдаан/- ны төрөлд 32 иргэнийг тус тус оролцуулж, тэмцээний үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг зарцуулсан.	
	Арга хэмжээ 2: Үндэсний уламжлалт спортын төрлүүдээр аймгийн хэмжээнд аймгийн аварга болон нэрэмжит тэмцээн тогтмол зохион байгуулах	Үндэсний спортын 7 төрлөөр аймгийн хэмжээнд тэмцээнийг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчийн ангиллаар зохион байгуулсан байна.	Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнийг спортын 6 төрлөөр зохион байгуулж тэмцээнүүдэд нийт 3706 тамирчдыг хамруулсан.	Үндэсний спортын 6 төрлөөр тэмцээн уралдааныг нас, насны ангиллаар зохион байгуулж оролцогчдын тоог нэмэгдүүлнэ.	Үндэсний спортын /шагай, мөсний шагай,сур харваа, мөсөн сур, үндэсний бөх, хурдан морь унаач/ 6 төрлөөр 42 удаагийн аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит, улсын аварга шалгаруулах тэмцээнд нийт 3210 тамирчдыг хамруулж, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллалаа.	100%
	Арга хэмжээ 4:	Аймгийн Үндэсний спортын холбоод,		2023 онд цоллооч	Тайлант онд үндэсний спортыг сурталчлан таниулж, өвлөн	100%



	<p>Үндэсний спортыг аймгийн өсвөр үе, хүүхэд багачуудад сурталчлан таниулах, өвлөн уламжлуулах,</p>	<p>багш, дасгалжуулагч нартай хамтран өсвөр үе, хүүхэд багачуудад үндэсний спортыг сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах зорилгоор бөхийн цол дуудах Цоллооч хүүхэд шалгаруулах уралдааныг зохион байгуулсан байна.</p>	<p>-</p>	<p>хүүхдийн уралдааныг зохион байгуулж 50 хүүхдийг хамруулна.</p>	<p>уламжлуулах зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагч хүүхдүүдийн дунд “Цоллооч, магтаал ерөөлч хүүхэд” шалгаруулах уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж, 60 хүүхдийг хамруулсан.</p>	
--	---	---	----------	---	--	--

<p>Зорилт 4. Спортын сургалт дасгалжуулалтын тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын</p>	<p>Арга хэмжээ 1: Аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах улс, бүс, олон улсын түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах</p>	<p>Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 17 төрлөөр 196 тамирчин бэлтгэсэн байна.</p>	<p>2022 онд спортын 16 төрлөөр өсвөрийн шигшээ багуудад 168 тамирчин хичээллэсэн.</p>	<p>2023 онд өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог 182-д хүргэнэ.</p>	<p>Тайлант онд өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж, спортын 16 төрөлд 182 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна. Тайлант онд өсвөрийн шигшээ багийн тамирчид "Монголын хүүхдийн спортын VII их наадам", улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 142 медаль хүртсэнээс алт 43, мөнгө 43, хүрэл медаль 56 авсан амжилтыг үзүүлсэн.</p>	<p>100%</p>
<p>ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын улс, бүс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,</p>	<p>Арга хэмжээ 2: Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад</p>	<p>Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин,</p>	<p>2021 онд хөл хорионы онцгой дэглэмтэй байсантай холбоотойгоор улсын аварга</p>	<p>2023 онд батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн урамшуулал олгоно.</p>	<p>Биеийн тамир, спортын газрын даргын 2023 оны 04 сарын 17-ний өдрийн "2022 онд олон улс, улсын чанартай тэмцээн уралдаанд амжилт гаргасан тамирчид дасгалжуулагчид, спортын холбоодуудад</p>	<p>100%</p>

	жил бүр мөнгөн шагнал олгох	дасгалжуулагчдад олгосон мөнгөн шагналын дүн, тамирчдын тоо	шалгаруулах тэмцээн зохиогдоогүй.		урамшуулал олгох тухай” А/52, А/54 дүгээр тушаалаар Тив, дэлхий, үндэсний баяр наадам, Монголын бүх ард түмний наадам, Монголын хүүхдийн спортын наадам, ахмад, залуучууд, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд медаль авсан нийт 455 тамирчинд 39,5 сая төгрөг, амжилт гаргасан шилдэг 5 дасгалжуулагч, 5 спорт холбоодод 4,7 сая төгрөг, нийт 44,2 сая төгрөгийн мөнгөн урашууллыг тус тус олгосон.	
	<b>Арга хэмжээ 3.</b> Үндэсний хэмжээнд зохиогдох спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнд орон нутгийн тамирчдыг амжилттай оролцуулж, амжилт гаргах	Хүүхдийн спортын наадам, Монголын Бүх ард түмний наадам, Үндэсний спортын их наадам, Оюутны спортын наадамд баг тамирчдыг амжилттай бэлтгэж оролцуулсан байна.	2022 онд Монголын бүх ард түмний зуны XV наадамд 21 төрлөөр 216 тамирчин өрсөлдөж багийн дүнгээр Орхон аймаг дэд байр, Монголын	2023 онд Монголын бүх ард түмний өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын зун, өвлийн VII наадамд баг тамирчдыг амжилттай оролцуулна.	Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймгаас 6 төрөлд 49 тамирчин оролцож багийн дүнгээр Дэд байр, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадамд 54 тамирчин оролцуулж 4-р байр, зуны наадамд 20 төрөлд 217 тамирчин оролцуулж багийн дүнгээр Дэд байрт шалгарч, тус тус амжилтыг үзүүлсэн.	100%

			үндэсний спортын VII наадамд 6 төрлөөр 96 тамирчин оролцож багийн дүнгээр Тэргүүн байр эзэлсэн.			
	Арга хэмжээ 4. Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Орон нутагт хөгжүүлж байгаа гранд гольф, софт волейболын спортыг сурталчлан жилд 4 удаа тэмцээн зохиох, хичээллэгчдийг 140-д хүргэх.	2022 онд шинээр хөгжиж байгаа спортын 3 төрлөөр 6 удаа тэмцээн зохион байгуулж 287 иргэн хамруулсан.	Шинээр хөгжиж байгаа спортын 3 төрлөөр 7 удаа тэмцээн зохион байгуулж, 300 иргэнийг хамруулна.	Тайлант онд шинээр бочи, мас-рестлингийн спортыг хөгжүүлж, спортын 5 төрлөөр 7 удаагийн тэмцээнд 400 орчим тамирчдыг хамруулсан. Шинээр хөгжиж байгаа софт волейбол, граунд гольф, бочи, корн-holl, мас-рестлингийн спортын төрлөөр 350 тамирчин биеийн тамир, спортын газрын А, Б заал, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н спорт цогцолборын заалнуудад 7 хоногт 6 өдөр 2 цагаар тогтмол хичээллэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• софт волейболын спортоор 120 тамирчин;</li> <li>• граунд гольфийн төрлөөр 130 тамирчин;</li> <li>• бочи спортын төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй 15 тамирчин;</li> </ul>	100%

					<ul style="list-style-type: none"> <li>• корн-holl спортын төрлөөр 45 тамирчин; мас-рестинг буюу модон барилдааны төрлөөр 40 тамирчин.</li> </ul>	
	Арга хэмжээ 5. Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, "Өвлийн спортыг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Өвлийн спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд хичээллэгчдийн тоог нэмэгдүүлж, тамирчдыг чадварыг сайжруулах, аймгийн аварга болон нэрэмжит тэмцээнийг зохион байгуулах	Хөтөлбөрийг 86.5%-иар хэрэгжүүлэн ажилласан.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 95%-д хүргэнэ.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 92.5 хувиар хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 100 хувийн биелэлттэй 13 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, 1 арга хэмжээг 40 хувиар биелүүлэн ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд шинээр 2 мөсөн талбай байгуулж өвлийн спортын мөсний сур харваа, мөсөн шагай, тэшүүр, шорт трекийн спортоор хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлсэнээр хичээллэгсдийн тоо 600-аар, тамирчдын тоо 342-оор тус тус нэмэгдэж нийт 2532 иргэн хичээллэдэг болсон. 2023 онд орон нутагтаа анх удаа	100%

					Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг нэгэн зэрэг өндөр түвшинд зохион байгуулж 12 аймаг, 7 дүүргээс 700 гаруй дасгалжуулагч, тамирчид, зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж зочид буудал, хоол үйлдвэрлэл, бэлэг дурсгал, хэвлэл мэдээлэл, бусад үйлчилгээний байгууллагуудаас Орхон аймагт нийт 1 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдсэн байна. Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадамд Орхон аймаг багийн дүнгээр 2-р байрт шалгарсан.	
	Арга хэмжээ 6. “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн болон ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд өвлийн спортоор хичээллэх орчин бүрдүүлэх	Өвлийн улиралд ерөнхий боловсролын 3 сургуулийн гадна талбайд мөсөн гулсуурын талбайг тохижуулах.	Аймгийн хэмжээнд цанын бааз 1, мөсөн гулгуурын гадна талбай 3 ажилласан.	Мөсөн гулгуурын талбайг 1 зэр нэмэгдүүлж, 4 мөсөн талбайг ашиглалтад оруулсан байна.	Тайлант онд 3 байршилд 7 зам талбай байгуулж спортын 8 төрлөөр /биатлон, гүйлтийн цана, уулын цана, снөүбоард, гүйлтийн тэшүүр, шорт трек, хоккей, мөсний сур харваа, мөсөн шагай/ 532 тамирчин хичээллэж, бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн уралдаан зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан нь өмнөх онтой	100%

					<p>харьцуулбал цана, тэшүүрийн зам талбайг 3-аар нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.</p> <p>- "Эрдэнэт спорт, амралтын хүрээлэн"-д гүйлтийн тэшүүр 400м мөсөн талбай;</p> <p>- "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д шорт трекийн зам талбай;</p> <p>- Сархиа цанын баазад гүйлтийн цана, уулын цана, снөүбоардын 3 зам;</p> <p>- Сархиа цанын баазын мөсөн талбай;</p> <p>- 19-р сургуулийн хоккейн талбайд цана, чарга, тэшүүрийн түрээсийн үйлчилгээг явуулж 2000 орчим иргэнийг хамруулсан.</p>	
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах						
Үндсэн чиг үүргийн нэр: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүрэг						
Зорилт 5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын	Арга хэмжээ 1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтыг хууль, журамд заасан хугацаанд гаргаж харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх	Тухай жилийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээгээр	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022 онд 97.4 хувиар биелүүлж ажилласан.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 онд 98 хувьд хүргэж ажиллана	Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөөний биелэлтийг 93%-иар биелүүлж ажилласан.	93%

<p>удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах</p>	<p>Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах,</p>	<p>Тухай жилийн байгууллагын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээгээр</p>	<p>2022 онд биелэлт-94%</p>	<p>2023 онд биелэлт-95%</p>	<p>Тайлант онд биеийн тамир, спортын тухай хуулийн 8 заалт, Ерөнхийлөгчийн зарлиг 4, Засгийн газрын тогтоол 2, Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоол 14 тус тус хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг 95,1 хувиар биелүүлж ажилласан.</p>	<p>93%</p>
	<p><b>Арга хэмжээ 3.</b> Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах</p>	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо</p>	<p>Шинээр баталсан хөтөлбөрийн биелэлтийг 30 хувиар хэрэгжүүлэн ажилласан.</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ.</p>	<p>Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр /2022-2025/-н хүрээнд 2023 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу ажлын байранд мэргэшүүлэх сургалтад 8 чиглэлээр 22 удаа давхардсан тоогоор 175 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7-4-10” 24 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 56 албан хаагч тус тус хамрагдаж, биелэлт 95%-иар хэрэгжүүлсэн.</p>	<p>95%</p>
	<p>Арга хэмжээ 4. Байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах</p>	<p>Биеийн тамир, спортын газрын хүний нөөцийн хөтөлбөр батлагдсан байна.</p>	<p>Шинээр баталсан хөтөлбөрийн биелэлтийг 25 хувиар</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ.</p>	<p>Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022-2025 оны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөнд нийт 42 арга</p>	<p>93%</p>



			хэрэгжүүлэн ажилласан		хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хугацаанд үргэлжлэн хэрэгжих 15, хэрэгжих боломжгүй 2, 15 ажлыг тус тус хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт 93.7%-тай байна. Хөтөлбөрийн хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооноос улсын төсвийн санхүүжилтээр ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулж ажилласан. Үүнд: 20 сая төгрөгийн компьютер, хувилах, хэвлэх төхөөрөмж, 20 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмж, 20 сая төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 60 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдаж, компьютер, хэвлэх, хувилах машинаар 90 хувь хангагдсан.	
Зорилт 6. Төсвийн шууд захирагч хууль тогтоомжийн дагуу төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл	Арга хэмжээ 1. Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах	Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв	2022 онд улсын төсвөөс цалин хөлс биеийн тамир спортын арга хэмжээнд 406.0 сая	2023 онд батлагдсан төсвийн хүрээнд өр авлагагүй ажилласан байна.	Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 12 дугаар сарын 01-ний байдлаар улсын төсвөөс 893,0 сая төгрөг, А болон Б спорт заалны урсгал зардалд орон нутгийн төсвөөс 488,4 сая төгрөгийг төсвийн	95%

ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах			төгрөг зарцуулсан		тухай хуулийн дагуу тус тус зарцуулж ажилласан.	
Зорилт 7. Хөрш зэргэлдээ Булган аймагтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Арга хэмжээ 1. Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах	Орхон, Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга нар хамтран ажиллах ажлын гэрээ байгуулан жил бүр ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.	2016-2020 онд Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлт 100% дүгнэгдсэн.	Орхон, Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга нар хамтран ажиллах ажлын гэрээ байгуулан жил бүр ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.	Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын 2023 оны хамтран ажиллах гэрээний хүрээнд биеийн тамир спортын чиглэлээр 4 үндсэн арга хэмжээг хэрэгжүүлж, гэрээний биелэлт 100%-иар дүгнэгдсэн.	100%
Зорилт 8. Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, байгууллагын дотоод хяналт	Арга хэмжээ 1. Байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн эцсийн тайланг гаргаж, хугацаанд нь хүргүүлэх, хамтран ажиллах гэрээ байгуулсан спорт	Жил бүр байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлж, хамтран ажиллах гэрээ	2020 оны хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг маягтын дагуу гаргаж ЗГТА-БТСУХ-нд хүргүүлсэн.	Жил бүр байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг маягтын дагуу гаргаж хугацаанд нь	Байгууллагын дотоод хяналт шалгалтын орон тооны бус комиссын 2022 оны хяналт шалгалтын дүгнэлт, 2023 оны 01-улирлын ажлын үр дүнд үндэслэн биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам боловсруулж, тус газрын	100%

шалгалтын комиссын ажиллагааг үйл	холбоодын төсөвт хяналт шинжилгээ хийх	байгуулсан спортын холбоодын батлагдсан төсөвт хяналт хийж ажилласан байна.		хүргүүлсэн байна.	даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
	Арга хэмжээ 2. Байгууллагын Дотоод хяналт шалгалтын комиссын гишүүд жилийн батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийх, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Дотоод хяналт шалгалтын комиссын гишүүд төлөвлөгөөний дагуу ажиллаж байгууллагад үүсэж болзошгүй зөрчил, дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилласан байна.	2022 онд дотоод хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж зөвлөмж өгч ажилласан	2023 онд дотоод хяналт шалгалтыг улирал бүр зохион байгуулж ажиллана.	Тайлант онд 4 удаа дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг 3 чиглэлээр буюу спортын холбоодын үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн чиг үүргийн хэрэгжилтийн чиглэлээр тус тус зохион байгуулсан. Төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулж, байгууллагын эзэмшил барилга байгууламжид үзлэг хийж, сайжруулах ажил хийгдсэн.	100%
Биелэлтийн дундаж-96,3%						

Баталгааны хуудас

Энэ хадгаламжийн нэгжид 18 (арван найм) хуудас + дотоод товъёогны  
/тоо, үсгээр/

1 (нэг) хуудас бүгд 19 (арван ес)  
/тоо, үсгээр/ /тоо, үсгээр/

хуудас дугаарлав.

Алгассан дугаар \_\_\_\_\_

Давхардсан дугаар \_\_\_\_\_

A3, A2 хэмжээтэй хуудасны дугаар \_\_\_\_\_

Дугтуй наасан, үдсэн хуудасны дугаар \_\_\_\_\_

Гэмтэлтэй, сэлбэн засагдсан хуудасны дугаар \_\_\_\_\_

Баталгааны хуудас бичсэн

Мэргэжлийн

ажилтны албан тушаалын нэр

М. Агуйн

гарын үсэг

М. Агуйн-Эрдэнэ

гарын үсгийн тайлал

2024 он 03 сар 04 өдөр